Аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллага нь аймгийн Засаг даргын тамгын газрын даргын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Увс аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,668,773.7 мянган төгрөгөөр буюу 28.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	17,403,579.9	9,606,165.9	-7,797,414.0
Бусад эргэлтийн хөрөнгө	11,482,714.9	7,014,218.9	-4,468,496.0
Үндсэн хөрөнгө	11,919,818.2	12,516,954.5	597,136.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>40,806,113.0</b>	<b>29,137,339.3</b>	<b>11,668,773.7</b>
Өр төлбөр	5,331.6	134,234.6	128,903.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	40,800,781.4	29,003,104.7	-11,797,676.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>40,806,113.0</b>	<b>29,137,339.3</b>	<b>11,668,773.7</b>

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардлын эхний болон эцсийн үлдэгдэл байхгүй байна.

Бараа материал дансны үлдэгдэл 9,606,165.9 мянган төгрөг болж 7,797,414.0 мянган төгрөгөөр буурсан нь Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг захиалагч байгууллагын хувьд аймгийн Орон нутгийн өмчийн газрын өгсөн чиглэлийн дагуу бараа материал дансанд бүртгэгдсэн 7,882,857.9 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 7,014,218.9 мянган төгрөг болж 4,468,496.0 мянган төгрөгөөр буурсан нь нөөцийн бараа материалд Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын өгсөн чиглэлийн дагуу бүртгэсэн болон ашиглагч байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 12,516,954.5 мянган төгрөг болж 597,136.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, программ хангамжийн 209,862.9 мянга, хадиваар авсан машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад үндсэн хөрөнгө 548,220.0 мянга, шилжүүлэн авсан тээврийн хэрэгсэл 139,000.0 мянга, бусад эх үүсвэрээс авсан тээврийн хэрэгсэл 507,000.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, мөн худалдсан тээврийн хэрэгсэл 70,000.0 мянга, акталсан машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил 113,082.0 мянга, тайлант онд 804,998.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 134,234.6 мянган төгрөг болж 128,903.0 мянган төгрөгөөр өссөн нь Сангийн яамнаас санхүүжилтийн эрх нээж өгөөгүй болон төсвийн тодотгол хийсэнтэй холбоотой үүссэн Нийгмийн даатгалын шимтгэл, Хувь хүний орлогын албан татвар, түлш халаалт, шуудан холбоо, гэрээний дагуу байгууллагад төлөх өр төлбөр үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 29,003,104.7 мянган төгрөг болж 11,797,676.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 6,409,997.9 мянга, үйл ажиллагааны орлогоос 10,000.0 мянга, нийт 6,419,997.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 6,419,997.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 850,814.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 7,270,812.1 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 7,226,033.8 мянга, өөрийн орлого 42,294.9 мянга, нийт 7,268,328.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,067,155.8 мянган төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь үндсэн дансны хэмнэлт гарсан байна. Үндсэн данснаас 201,173.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80101 үндсэн үйл ажиллггааны зардал	3,714,568.3	3,560,244.2	154,324.1	
2	80103-гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	1,677,481.9	1,677,473.0	8.9	
3	80111-Төрийн өмчийн барилгын ашиглалт	675,562.0	675,405.6	156.4	
4	80205-мэдээлэл сурталчилгааны зардал	24,600.0	15,605.0	8,995.0	
5	80307, шүүхийн шийдвэрийн дагуу олох нөхөн төлбөр	39,969.2	39,969.2	0.00	
6	80309 -уналга, цугларалт бэлтгэл сургууль	66,500.0	54,842.5	11,657.5	
7	80802-ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг	295,434.0	275,403.0	20,031.0	
8	80815- сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор	21,213.4	21,213.36	0.04	
9	Орон нутгийн нөөц хөрөнгө	747,000.0	747,000.0	0.00	
	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000.0	0.0	6,000.0	
		7,268,328.8	7,067,155.86	201,173.0	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

№	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	/мянган төгрөг/
					Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл		50,475.0		Санхүүгийн Ctsystem, Ухаалаг Увс апплейкешн

2	Унаа, хоолны зардал	133,254.2	130,068.2	3,186.0	Ажилтнуудад хоолны хөнгөлөлтийг 1 хоногт 4.5 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар	30,000.0	24,506.4	5,493.6	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гарсан.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	95,936.2	0.00	Гадаад зочин хүлээн авах арга хэмжээ- 37,084.4, гадаад томилолт /Засаг даргын нөөц, техник хяналтын зардлаас- Улаанбаатарт ажилласан томилолтын хэмжээгээр тооцсон, унааны зардал орсон/-58,851.8
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал		39,939.2		Шүүхийн шийдвэрийн дагуу 2 ажилтанд олгосон байна. Аудитаар уг асуудлыг Төрийн албаны салбар зөвлөлд албан бичиг хүргүүлэхээр шийдвэрлэсэн.
6	Орон тооны цомхотгол		0.0		Үйлчилгээний 6 орон тооны цомхотгол хийсэн.
7	Хэвлэл, мэдээлэл		103,000.0		Цахим сайт, телевиз /Аймгийн 100 жилийн ой болсонтой холбоотой зардал нэмэгдэж гарсан/

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах аймаг орон нутгийн байгууллагын шийдвэрээр 4,869,638.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 99,180.9 мянга, нийт 4,968,818.9 мянган төгрөгийн орлого бүртгэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас цалингийн зардалд 57,626.7 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 7,667.9 мянга, тээвэр шатахууны зардалд 840.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн эд зүйлсийн зардалд 76,350.2 мянга, бичиг хэргийн зардалд 714.2 мянга, урсгал засварын зардалд 4,439.0 мянга, дотоод албан томилолтын зардалд 63,615.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,327,412.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 2,774,663.6 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 116,761.00 мянга, бусад хөрөнгийн зардалд 91,350.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 331,710.0 мянга, нийт 4,853,150.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулаагүй үлдэгдэл 115,668.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Засаг даргын тамгын газарт тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аймгийн Засаг даргын тамгын газар нь тайлант онд 1,065,000.0 мянган төгрөгийн Ю.Цэдэнбалын нэрэмжит аймгийн төв талбайн шинэчлэл тохижилтын ажил, тээвэр шатахуун нийлүүлэх 161,097.3 мянган төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалтыг

цахимаар, мөн 49,280.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулж ажилласан байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 3/156 дугаар албан бичгээр ирүүлсэн.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 10,821,217.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 108,212.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 86,569.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 12,875,742.2 мянган төгрөгийн 1 хувиар буюу 128,757.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 103,005.9 мянган төгрөгөөр тогтоосон.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Аймгийн Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Засаг даргын тамгын газар нь бараа үйлчилгээний бусад зардал, мэргэжлийн үйлчилгээний төлбөр, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас аймгийн 100 жилийн ойн үйл ажиллагаанд зориулж бэлгийн багц худалдан авахад төсвөөс 28,065.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага өглөө.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын тамгын газар нь тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд төсөв, хөрөнгө зарцуулах 6,142,153.6 мянган төгрөгийн 80 шийдвэрийн мэдээллийг байршуулаагүй, мөн төсөв, хөрөнгө зарцуулах 2,626,751.7 мянган төгрөгийн 99 шийдвэрийн мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 3,532,977.6 мянган төгрөгийн 188 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 11,252,140.9 мянган төгрөгийн 108 мөнгөн гүйлгээг тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Аймгийн Засаг даргын тамгын газар нь Шүүхийн шийдвэрийн дагуу доорх ажилтнуудад ажилгүй байсан хугацааны цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нийт 39,969.2 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас олгосон байна. Үүнд:

Шүүхийн шийдвэрийн дагуу цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын судалгаа

Д/д	Нэрс	Огноо	Мөнгөн дүн	Шүүхийн шийдвэр
			Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	
1	Б.Чимэддорж	2024.12.20	20,588,746	2024.08.01, №152/ШШ2024/00336 2024.11.12, №152/ШШ2024/00499
2	Ш.Батмөнх	2024.12.20	19,380.463	2024.06.26, №224/МА2024/00025 2024.09.24, №152/ШШ2024/00404
	<b>Нийт дүн</b>		<b>39,969,209</b>	

Энэ асуудлыг Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", 50.2 дахь "Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана" гэж заасны дагуу Төрийн албан салбар зөвлөлд шилжүүлэхээр шийдвэрлэв.

2. Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн сангийн төлбөр тооцоо хариусан мэргэжилтэн, Салбарын хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, Мэдээлэл технологи, цахим засаглалын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн гэсэн албан тушаалуудад түр орлон гүйцэтгэгч томилон ажиллуулж байгаа асуудлыг Төрийн албаны зөвлөлийн Увс аймаг дахь салбар зөвлөлд албан бичиг хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 16,490,168.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрүүлж 85,019.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 16,404,648.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 500.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлэн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нарт татварын мэргэшсэн зөвлөхийн эрхийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг сар бүр үндсэн цалингийн 15 хувиар тооцож олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2 дахь хэсэгт “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс” бүрдэнэ гэж заасантай нийцэхгүй байх тул дараагийн аудитаар тухайн зөрчлийг арилган ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.
2. Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Б/11 дүгээр захирамжаар Засаг даргын зөвлөх, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн Б/56 дугаар захирамжаар Засаг даргын төсөл, хөтөлбөр хариуцсан ахлах зөвлөх томилж 63,056.1 мянга, 2025 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн Б/57 дугаар захирамжаар Засаг даргын зөвлөх томилж 18,182.1 мянга, 2025 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн Б/58 дугаар захирамжаар Засаг даргын зөвлөх томилж 18,967.0 мянган төгрөгийн цалин тус тус олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт “Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно” гэсэн заалтад нийцэхгүй байх тул уг асуудлыг аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн нэгтгэл тайланд хийх аудитаар шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 23,582,089.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 23,554,023.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 28,065.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага өглөө.

## Залруулсан алдаа:

Санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдлийг 2,289.4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 дахь заалтад “бүх өр төлбөр” гэж заасан болон Толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулга хийлгэлээ.

### 5.1 Албан шаардлага

Увс аймгийн Засаг даргын тамгын газар нь бараа үйлчилгээний бусад зардал, мэргэжлийн үйлчилгээний төлбөр, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас аймгийн 100 жилийн ойн үйл ажиллагаанд зориулж бэлгийн багц худалдан авахад төсвөөс 28,065.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалт болон “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс хуулиар хориглосон зардал буюу бэлэг дурсгалыг зүйлд зардал гаргахгүй ажиллахыг албан шаардлага болгов.

### 5.2 Зөвлөмж

*Илрүүлэлт:*

Аймгийн Засаг даргын тамгын газар нь тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд төсөв, хөрөнгө зарцуулах 6,142,153.6 мянган төгрөгийн 80 шийдвэрийн мэдээллийг байршуулаагүй, мөн төсөв, хөрөнгө зарцуулах 2,626,751.7 мянган төгрөгийн 99 шийдвэрийн мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 3,532,977.6 мянган төгрөгийн 188 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 11,252,140.9 мянган төгрөгийн 108 мөнгөн гүйлгээг тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өглөг дутуу илэрхийлсэн	1	2,289.4	1	2,289.4			1	2,289.4				
Дүн	1	2,289.4	1	2,289.4			1	2,289.4				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй	1	28,065.5			1	28,065.5							
Дүн	1	28,065.5			1	28,065.5							

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроосон мөн байршуулаагүй	1	23,554,023.8					1	23,554,023.8
Дүн	1	23,554,023.8					1	23,554,023.8
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	23,554,023.8					1	23,554,023.8

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.НАМЖИЛ/

2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

**АЛБАН ШААРДЛАГЫН БҮРТГЭЛ,  
ХЯНАЛТЫН ХУУДАС**

**А. Албан шаардлагын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт**

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Увс аймгийн ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	УВА-2026/023/НА-СТА-ТШЗ
-----------------	---	-----------------	-------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	---	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлагын дугаар		1.6 Огноо	2026.02.25	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	28,065,500
-----------------------------	--	-----------	------------	----------------------------	------------

1.8 Албан шаардлага өгөх үндэслэл	Алдаа, зөрчлийн товч утга	Увс аймгийн Засаг даргын тамгын газар нь бараа үйлчилгээний бусад зардал, мэргэжлийн үйлчилгээний төлбөр, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас аймгийн 100 жилийн ойн үйл ажиллагаанд зориулж бэлгийн багц худалдан авахад төсвөөс 28,065.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.			
	Алдаа, зөрчлийн ангилал	Хууль, тогтоомжийг хэрэгжүүлээгүй			
	Журмын заалт (4.2-ос аль тохирохыг оруулах)	4.2.1.6 дахь заалтад “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.11 дэх заалтад “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль		
		Заалт	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”		
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6, 4.2.1.11 дэх заалт			
	Заалт	4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” 4.2.1.6 дахь заалтад “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа,			

зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”

1.9 Зөрчил барагдуулах хэлбэр /Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	1.10 Зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	
	Тухайн байгууллагын дансанд	
	Зөрчил арилгаж	
		2026.05.30

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл


№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Төлбөрийн хүсэлт		2025	8 дуаагийн гүйлгээний төлбөрийн хүсэлт хавсралтаар
2	Холбогдох нотлох баримтууд		2025	Тушаал шийдвэр, нэхэмжлэх, орлого, зарлагын баримт, гэрээ гэх мэт

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл


№	Аудитын багийн		Хариуцагч			
	Албан тушаал	Овог нэр	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Ахлах аудитор	Т.Намжил	Аймгийн ЗДТГ	Дарга	У.Ганзориг	99454989
				Нягтлан бодогч	Н.Алтантуул	99454389

Албан шаардлага бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Аудитын менежер М.Бат-Амгалан	2026.02.25	-	
2	Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	2026.02.25	—	

4.2 Албан шаардлагыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Дарга, тэргүүлэх аудитор	М.Батсуурь	2026.02.25	

4. Албан шаардлагыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг		
		8066666	1528010041	
			Гайлбар	
1	Албан шаардлагыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлагыг хүлээлгэн өгсөн	Огноо	2026.02.25	
		Ажилтны	Овог нэр	Т.Намжил
			Албан тушаал	Ахлах аудитор
3	Албан шаардлагыг хүлээн авсан	Байгууллагын нэр	Аймгийн ЗДТГ	
		Ажилтны	Овог нэр	Н.Алтантуул
			Албан тушаал	Нягтлан бодогч
4	Албан шаардлагын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр	Аймгийн ЗДТГ	
		Ажилтны	Овог нэр	У.Ганзориг
			Албан тушаал	Дарга
5	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		



УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/38/А2060412  
УБА-2026/023/НА-СТА-ТМЗ

Улаангом

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтад заасан цаглаварт хугацаанд аймгийн Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Увс аймгийн Засаг даргын тамгын газар нь бараа үйлчилгээний бусад зардал, мэргэжлийн үйлчилгээний төлбөр, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас аймгийн 100 жилийн ойн үйл ажиллагаанд зориулж бэлгийн багц худалдан авахад төсвөөс 28,065.5 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5 дахь заалтад “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтад “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” 4.2.1.6 дахь заалтад “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн хөрөнгөөр хуулиар хориглосон зардал буюу бэлэг худалдан авахыг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар<sup>2</sup> т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга У.Ганзориг, нягтлан бодогч Н.Алтантуул нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

Т.НАМЖИЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ

